

БАТЛАВ
 БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
 ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
 ДАРГЫН АЛБАН ДҮРБИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ.....С.ДОГТГЭРЭЛ

**СҮХБААТАР АЙМАГТ 105 ГА ГАЗАРТ ТАТМЫН ОЙЖУУЛАЛТ ХИЙХ АЖЛЫН
 ДААЛГАВАР, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Гэрээгээр гүйцэтгэх ажлын дугаар: Төслийн 2024 оны ажлын төлөвлөгөөний 2.2.6 г

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1	Ажил гүйцэтгэх үндэслэл	<p>Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн газар хамтран “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийг 2021 оны 3 дугаар сараас эхлэн Дорнод, Сүхбаатар, Завхан, Ховд аймагт хэрэгжүүлж байна. Төсөл хэрэгжсэнээр шууд байдлаар 130,000 орчим, шууд бус байдлаар 800,000 гаруй малчин иргэд төслийн үр шим хүртэхээс гадна тэдгээрийн 50 хувь нь эмэгтэйчүүд байна. Төслийн зорилго нь байгалийн нөөцөөс хамааралтай, уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий малчдын дасан зохицох, эрсдэлийг даван туулах чадамжийг сайжруулан бэхжүүлэх юм. Тус зорилгод хүрэхийн тулд хоорондоо уялдаатай дараах бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэн үр дүнд хүрэх болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Бүрэлдэхүүн хэсэг 1: Үндэсний болон бүс нутгийн түвшинд газар, усны нөөцийн төлөвлөлтийг уур амьсгалын мэдээлэлд тулгуурлан төлөвлөж, ашигладаг болох; • Бүрэлдэхүүн хэсэг 2: Байгалийн нөөцийн менежментэд малчдын байгууллагын оролцоог нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ус, хөрсний менежментийн арга ажиллагааг өргөн хүрээнд нэвтрүүлэх; • Бүрэлдэхүүн хэсэг 3: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, гарал үүсэл нь тогтвортой малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх малчдын чадавхыг нэмэгдүүлэх зэрэг болно. <p>Хүний, малын нөлөөлөл, хортон шавж, түймэр, уур амьсгалын өөрчлөлт зэргээс үүдэн Монгол орны татмын ойн нөөц эрс хомсгож, зарим газар бүрэн устаж, гол мөрний орчмын хөрсний чийг алдагдан экосистем ихээр доройтож байгаа учраас татмын ойжуулалт хийн нөхөн сэргээх зайлшгүй шаардлага үүсээд байна. Иймд, “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөл зорилгот 4 аймгийн хэмжээнд 2500 га талбайд татмын ойжуулалт хийх юм.</p>

	Сум	Талбай №	Талбайн хэмжээ, га	Хашааны хэмжээ, м	
					Ажлын нэр, төрөл
2	Ажлын хамрах хүрээ	Түмэнцогт	1	10	1310
		Түмэнцогт	2	10	1550
		Түмэнцогт	3	10	1330
		Түмэнцогт	4	10	1280
		Түмэнцогт	5	10	1300
		Түмэнцогт	6	10	1370
		Түмэнцогт	7	10	1360
		Түмэнцогт	8	10	1400
		Түмэнцогт	9	12	1550

		Нийт	9	92	12450
		Дарьганга	1	4	820
		Нийт	1	4	820
		Наран	1	9	1800
		Нийт	1	9	1800
			11	105	15070
		Талбайн захын цэг болон дэлгэрэнгүй мэдээлэл хавсралтаар оруулав.			
3	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээнд заасан хугацаанд			
4	Захиалагч байгууллага	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ЗГХА Ойн газар, Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар			
5	Төсөвт өртөг, тоо хэмжээ	<p>Нийт төсөвт өртөг: 1,181,250,000 (Нэг тэрбум зуун нааян нэгэн сая хоёр зуун тавин мянга)</p> <p>Багц 1 Нийт 92 га талбайд Түмэнцогт сумын нутагт татмын ойжуулалт хийнэ. Нийт төсөвт өртөг 1,035,000,000 Нэг тэрбум гучин таван сая төгрөг</p> <p>Багц 2 Нийт 13 га талбайд Дарьганга, Наран сумын нутагт татмын ойжуулалт хийнэ. Нийт төсөвт өртөг 146,250,000 Зуун дөчин зургаан сая хоёр зуун тавин мянган төгрөг</p>			
6	Ажил гүйцэтгэхэд тавигдах ерөнхий шаардлага	<p>Ажлыг гүйцэтгэх явцад бүх ажлыг холбогдох хүчин төгөлдөр хууль, тогтоомж, ойжуулалтын ажилтай холбоотой норм, стандарт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журам болон төслийн БОНМХХ-нд заасан арга хэмжээг хэрэгжүүлж, хийгдэх ажлын тоо хэмжээний дагуу, захиалагч талтай нягт хамтран, чанарын шаардлагыг хангаж ажиллана.</p> <p>Ойжуулалтын ажлын гүйцэтгэгч нь шалгарсан тохиолдолд тухайн ойжуулалт хийж байгаа байршилтай ойролцоох малчдын байгууллагатай гэрээ байгуулж ойжуулалтын ажил хамтран гүйцэтгэх, мөн гэрээнд ойжуулсан талбайн 3 жилийн арчилгаа, хамгааллыг малчдын байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг тусгасан байна.</p>			
7	Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага	<ul style="list-style-type: none"> • Тарьц суулгацын нөөц хангалттай байх (худалдан авах бол нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ). • Мод үржүүлэг, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөлтэй ойн мэргэжлийн байгууллага байна. • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх ажилчдын 50-аас доошгүй хувь нь ойролцоо нутгийн малчдын байгууллагын гишүүдээс бүрдсэн байх. • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэхдээ НҮБХХ-ийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн стандарт, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах байгаль орчны мэргэжилтэнтэй байна. 			
8	Гүйцэтгэх ажлын үе шат	Татмын ойжуулалт нь бэлтгэл ажил, ойжуулалт хийх, хамгаалах хүлээлгэн өгөх, зөрчил, гологдол арилгах, гүйцэтгэлийн болон байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан боловсруулах, тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх гэсэн үе шатуудтай байна.			
9	Бэлтгэл үе шат	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлж, батлуулах • Татмын ойжуулалтын ажил гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг дадлагажуулах, 			

		<ul style="list-style-type: none"> • Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх чиглэлээр ажилчдад сургалт хийх (анхаарах чиглэлүүдийг 18 хэсэгт заав), • Ойжуулалтын ажилд хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн ажилд гарахад бэлэн болгох, • Ойжуулалтын ажлын технологийн карт, дараалал боловсруулан ажилчдад танилцуулж дагаж мөрдөх (технологийн дарааллыг хавсаргав), • Ойжуулалтын ажлын сонгогдсон талбайн эргэлтийн цэгийг тэмдэгжүүлэх (Төслийн Гомдол барагдуулах механизмын хүрээнд гомдол, санал хүлээн авах хайрцгийг байршуулах), • Татмын ойжуулалтын ажил гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэх өгөх, • Татмын ойжуулалтын ажил гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ойн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх, • Ойр орчмын иргэдэд мал бэлчээхийг хориглох, ойжуулалтын талбайн дундуур гаргасан мал услах орц, гарцын талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах, ойжуулалт хийх төлөвлөгөөнд оруулах , • Тусгаарласан талбай тутамд нэг усжуулалт хийх тоног төхөөрөмж (1-5тн багтаамжтай усны нөөц савтай, ус шахагч, d40 крант гэх мэт) байна. • Тусгаарласан талбай тус бүрийн хашаа 1.5 метрээс доошгүй өндөртэй • Татмын ойжуулалтын хашааг 10 га тутамд 2 м өргөнтэй гарц гарган хийнэ.
10	Хашаа барих	<ul style="list-style-type: none"> • Хашаанд тавигдах шаардлага • Хашааны шонгийн өндөр: 2.0м, шонгийн далавчны зузаан 1,8-2мм, Шонгийн далавчны нүхтэй талын урт 3 см, Шонгийн далавчны нүхгүй талын урт 1,8-2см, Хашаа нь салхины хурд, цаг агаарын ачааллыг даахуйц бат бөх тогтвортой байна • Тулгуур шонгийн хананы зузаан 2.5-3мм, 20-30м тутамд нэг тулгуур шон хийнэ. Торны дээгүүр шон хооронд нэг эгнээ 3мм цайрдсан төмөр утсаар бэхэлгээ хийж, цайрдсан төмөр чангалагчаар бэхэлнэ. Шон хоорондын торны гадна талд 3мм диаметртэй төмөр утсаар Х бэхэлгээ хийнэ. • Машин орох хаалганууд сайн чанарын нугастай, цүүтэй, зүүдэн цоожтой байх ба дотор талдаа бат бэх замган түгжээтэй байна. • Машин орох хаалганы Шонгийн газарт суух гүн 70 см-ээс багагүй байж БМ150 маркийн бетоноор цутгаж шонг бэхэлж өгнө. Хаалга нь 5мм-н цайрдсан төмөр торон материалаар хийгдсэн байна. Машины хаалга 2 шон дээрээсээ чангалагч татуургатай байна. • Явган хүний хаалганд сайн чанарын нугас, түгжээ суурилуулна. • Ажил гүйцэтгэх талбайн үүдний хэсэгт 0.5x1 метр хэмжээтэй ажлын гүйцэтгэгч, захиалагч, талбайн хэмжээ, тарьсан модны тоо, схем талбайд мал бэлчээхийг хориглосон анхааруулга зэрэг мэдээлэл агуулсан самбар байрлуулах • Талбайн 4 буланд гадагш нь 3мм-ээс багагүй диаметртэй төмөр утсаар гадагш татлага хийж булангийн шонг газарт гадаслаж бэхэлнэ. • Татмын ойн хашаажуулалтын ажлын зураг төсвийг баримталж ажиллана (хавсаргав). • Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх үндсэн шаардлагуудыг баримталж ажиллана (18 дахь хэсгийг харна уу).
11	Усалгааны систем	<ul style="list-style-type: none"> • Зөөврийн хуванцар хийцтэй, 1 тонн багтаамжтай 5 ширхэг эсвэл 5 тонны ус нөөцлөх сав байрлуулах • Ус нөөцлөх савнаас хаалт угсарч, ус шахах зориулалттай бензин мотопомп байрлуулах /мотопомп нь усалгааны системээр ус шахахад хангалттай хүчин чадалтай байх/ • Татмын ойжуулалт хийх талбайд хүрэлцэхүйц хүчин чадал багтаамжтай байна.


“Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага” MNS6141:2010 стандартыг хангасан суулгацыг татмын ойжуулалтын ажилд хэрэглэх,

- Татмын ойжуулалтын талбайг хашиж хамгаална. Ингэхдээ уулын налуу болон жалгын ховилоор хашаан доогуур мэрэгч амьтан болон мал орохоос хамгаална. (Хамгаалалтын хашааны батлагдсан жишиг зургийг хавсаргав – хэмжээ: 250м * 100м),
- “Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах арга. Ерөнхий шаардлага” MNS6258-1:2011 стандартын дагуу суулгацын нүхийг бэлтгэх эсвэл шан (шуудуу) татаж болно. Шан татах бол тарилтийн эгнээг шангаар гаргана. Шангийн өргөн 30 см-ээс ихгүй, гүн нь 20 см-ээс ихгүй байх бөгөөд суулгац суулгах байршилд нүх ухах
- Татмын ойжуулалтын ажлыг 10-р сарын 01-наас 11-р сарын 01 хүртэл хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд нөхөн тарилтыг 5-р сарын 01-наас 6-р сарын 01-ны өдрийн дотор тус тус хийх,
- Тарьсан суулгацыг арчлах, гаднын хүчин зүйлээс хамгаалах, тогтмол усалгааны ажил гүйцэтгэх,
- Эгнээ хоорондын зай 4 метр, мод хоорондын зай 3 метр байхаар тооцон 1 га талбайд 800 ширхгээс доошгүй стандартын шаардлага хангасан чанартай суулгацаар тарилт хийх.
- Суулгацын стандарт хангасан байх хэмжээ

Модны төрөл	1-р зэргийн суулгац (өндөр, м)	2-р зэргийн суулгац (өндөр, м)	3-р зэргийн суулгац (өндөр, м)
Улиас	1.5 ба дээш	1.0-1.5	0.8-1.0
Хайлаас	0.8 ба дээш	0.6-0.8	0.4-0.6
Бургас	1.2 ба дээш	0.8-1.2	0.6 -0.8

12

Татмын ойжуулалт хийх



- Татмын ойжуулалтын талбайд суулгац суулгахаас 3-4 хоногийн өмнө ухсан нүхийг нэг удаа усална. Суулгацыг суулгасны дараа 35-40 см гүнд нэвчиж усална.
- Ургамал ургалтын хугацаанд намар тарьсан тохиолдолд цэнэг усалгааг 1-2 удаа хийж орхиод өвөлжүүлнэ. 4-р сарын 15-с эхлээд цэнэг усалгааг хийнэ. 5 ба 6-р сард 10-14 хоногийн зайтай, 7 ба 8 сард 14-16 хоногийн зайтай 2 удаа усална. 9-р сард нэг удаа усална. Усалгааны норм нь нэг га-д 500-700 м³ ус орохоор тооцно.
- Усалгааны норм, услах хугацаа нь тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс хамаарч өөрчлөгдөхийг анхаарах хэрэгтэй.
- Ургамал ургалтын нийт хугацаанд 10-13 удаа усалгааг хийнэ. Харин хаврын салхи ихтэй үед салааны завсар өнгөн хэсгийн хөрс хаталтаас сэргийлж усалгааг нэмэлт болгож хийх.
- Мэдээллийн самбар байрлуулах (нийт өндөр нь 3 метрээс багагүй төмөр хийцтэй байх бөгөөд самбарын хэмжээ 1x1 метрээс багагүй (самбарт ойжуулалт хийсэн талбайн зураг, захиалагч болон гүйцэтгэгчийн тухай


		мэдээлэл, талбайн хэмжээ, тарьсан модны төрөл, тоо ширхэг зэрэг мэдээллүүд багтана), самбарын хөлийг бетон зуурмагаар бэхэлсэн байна.		
14	Талбайг хүлээлгэн өгөх	<ul style="list-style-type: none"> Татмын ойжуулалтын талбайг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт, мөн тухайн аймаг, сумдад акт үйлдэн хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна. Актыг 5 хувь үйлдэн нэг хувийг Ойн газарт, төслийн төв нэгжид тус тус хүргүүлнэ. Тарьц суулгацын амьдралын хувийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03-р сарын 29-ний өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмын дагуу жишиг байгуулан тооллого явуулна. 		
		Татмын ойжуулалтын талбай /га/	Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь	Нэгж жишиг талбайн хэмжээ /м2/
		1 – 5	5	200
		6 -10	4	400
		11-20	3	400
		21-ээс дээш	2	400
	<ul style="list-style-type: none"> Татмын ойжуулалтын ажлыг хүлээн авахдаа гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил гологдлыг арилгасны дараа "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмаар батлагдсан актын дагуу хүлээн авна. Актын маягтыг хавсаргав. /Маягт№ГМ-4 / 			
15	Зөрчил, гологдол арилгах	<ul style="list-style-type: none"> Тарьсан тарьц, суулгац 50-74,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 90 хувь хүртэл нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгснөөр үлдэгдэл санхүүжилтийг тухайн жилд багтаан олгоно. Тарьсан тарьц, суулгац нь 25-49,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон нормативд зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна. Тарьсан тарьц, суулгац нь 24,9 хүртэл хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойжуулалтын ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ. Захиалагчийн хяналт болон ажил хүлээлцэхэд гарах зардлыг жишиг зураг төсвийн талбай бүрийн зохих дүнгээр тооцох бөгөөд гүйцэтгэгч тал бүрэн хариуцна. 		
		<ul style="list-style-type: none"> Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 2 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: а/ "Татмын ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайлан" б/ 1:50 000-ны масштабтай Татмын ойжуулалтын ажил явуулсан талбайн зураг в/ "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт. А. "Татмын ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайлан"-д Татмын ойжуулалт хийсэн ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт, болон төслийн Байгаль орчин, нийгмийн менежментийн хамрах хүрээнд (БОНМХХ) заасан арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн зэрэг мэдээллийг багтаана. Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, 		
16	Тайлан боловсруулах	<ul style="list-style-type: none"> Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 2 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: а/ "Татмын ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайлан" б/ 1:50 000-ны масштабтай Татмын ойжуулалтын ажил явуулсан талбайн зураг в/ "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт. А. "Татмын ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайлан"-д Татмын ойжуулалт хийсэн ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт, болон төслийн Байгаль орчин, нийгмийн менежментийн хамрах хүрээнд (БОНМХХ) заасан арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн зэрэг мэдээллийг багтаана. Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, 		

		<p>ойжуулалтын ерөнхий байдлын зураг, эхлэл төгсгөлийн зургийг харьцуулсан байдлаар фото хэлбэрээр тайланд хавсаргана.</p> <ul style="list-style-type: none"> • Б. "Татмын ойжуулалтын ажил явуулсан талбайн зураг"-т, Талбайн хилийн солбицол, дугаар, талбайн хэмжээ, газрын төрлийн ангилал, тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлолд, зургийн масштаб, проекц, таних тэмдэгт эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна. • В."Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт тайланд хавсаргана. Тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллүүдэд танилцуулан, хэлэлцүүлж хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Зөрчил гологдлыг арилгасны дараа тайланг дахин хянаж хүлээн авна. • Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтын тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (Universal Transvers Mercator) тусгагийг хэрэглэнэ. Татмын ойжуулалтын ажлын тайлан болон зургийн ship. Файлуудыг цахим хэлбэрээр 1 хувь ирүүлнэ. Ойжуулсан талбайн кадастрын зураглалыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, газрын кадастрын нэгдсэн мэдээллийн санд тусгуулна. • Ойжуулалт хийх хугацаанд НҮБХХ-ийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлуудын тайланг төсөл хэрэгжүүлэх нэгжид (ТХН) хүлээлгэн өгч батлуулна. Үүнд: • А. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж ажиллаж буй талаарх явцын тайланг /зурагт нотолгоо бүхий тайлан байна/ ойжуулалтын ажлын явцын тайланг ирүүлэх үед ТХН-д заавал хүргүүлнэ. • Б. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулж, эрсдэлээс сэргийлж ажилласан талаарх эцсийн тайлан /зурагт нотолгоо бүхий тайлан байна/.
17	Тайланг хэлэлцүүлэх хүлээлгэн өгөх	<p>Ойжуулалтын ажлын тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллүүдэд танилцуулан, хэлэлцүүлж 3 хувь үйлдэн Ойн газар, аймгийн БОАЖГазар, болон төслийн төв нэгжид хүлээлгэн өгнө.</p> <p>Ойжуулалт хийх хугацаанд НҮБХХ-ийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлуудын тайланг төсөл хэрэгжүүлэх нэгжид (ТХН) хүлээлгэн өгч батлуулна.</p>
18	Бусад тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> • Галын аюулгүй байдлыг анхаарч норм дүрмийн шаардлагын дагуу ажлыг гүйцэтгэнэ; • Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай нийт ажилчдын 50 ба түүнээс дээш хувийг тухайн сум орон нутгийн иргэд, малчдын байгууллага, бүлэг нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ. • Ойжуулалтын ажлын дараагаар таримал ургамлыг 3 жилийн туршид арчлах, гаднын хүчин зүйлээс хамгаалах арга хэмжээг тухайн орон нутгийн малчдын байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ; • Ажлыг гүйцэтгэх явцдаа ажлын үе шат бүрд захиалагчид фото зургаар баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгч үе шатны ажлыг эхэлнэ. • Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зөвхөн зөвшөөрөгдсөн замаар явуулах, зөвшөөрөгдсөн хурдаас хэтрүүлэхгүй байх, салаа зам гаргахгүй байх зэрэгт анхаарах • Санамсаргүй байдлаар шингэн/тос асгарч бохирдол үүсэхээс сэргийлэх, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж ажиллах, шингэн/тос

		<p>асгарах, алдагдах үед ашиглах багаж хэрэгсэл байгаа эсэх, санамсаргүй асгарсан шатах тослох материалыг голын эрэг дагуух хөрс, усанд орохоос сэргийлэх талаар ажилчдад сургалт хийх</p> <ul style="list-style-type: none"> • Машин механизм, тээврийн хэрэгслийн ашиглагдаагүй үе тогтмол унтраах, агаар орчныг бохирдуулахгүй байхад анхаарах, хог хаягдлыг ил задгай шатаахыг хориглох • Үйл ажиллагааг зөвхөн ажлын цагаар хийх, ажлын цаг дууссаны дараа чанга дуу чимээ гарах үйл ажиллагаа явуулахгүй байхад анхаарах • Үйл ажиллагаа явуулж байгаа газарт хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлын зохистой менежментийн чиглэлээр ажилчдадаа сургалт хийсэн байх, шатах тослох материал зэрэг аюултай хог хаягдлыг хадгалах, зайлуулах чиглэлээр мэдлэг мэдээллийг ажилчдадаа өгсөн байх, • Төслийн нэгжийн заасан төрөл зүйлийг мод буюу тухайн экосистемд тохирсон унаган төрөл зүйлийг тарихыг хатуу анхаарах. • НҮБХХ-ийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх стандарт үйл ажиллагааны дүрэм журмыг чандлан мөрдөх үүднээс ТХН-ээс өгсөн зааварчилгаатай танилцаж, шаардлагатай сургалтыг хийж, мөрдөж ажиллах
--	--	--

ТАНИЛЦСАН:

Уур амьсгалын өөрчлөлтийн газрын дарга, Төслийн захирал:



Ш.Цэрэндулам

Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга:



Ц.Уранчимэг


ЗГХА Ойн газрын дарга:



Б.Оюунсанаа

ХЯНАСАН:

Төслийн үндэсний зохицуулагч:



Ю.Баяржаргал

ЗГХА Ойн газар ахлах мэргэжилтэн



Б. Өсөхбаяр

БОЛОВСРУУЛСАН:

Төслийн газар ус хариуцсан техникийн мэргэжилтэн:



Б.Гүнсмаа

Хавсралт


Татмын ойжуулалт хийх талбайн дэлгэрэнгүй мэдээлэл

Аймаг	Сум	Захын цэг	Солбилцол	Өндөршил (м)
	Түмэнцогт	1	47.78580231	112.5608111
	Түмэнцогт	2	47.78849038	112.5586868
	Түмэнцогт	3	47.78835408	112.5547366
	Түмэнцогт	4	47.7863419	112.5543121
	Түмэнцогт	1	47.78329786	112.5611791
	Түмэнцогт	2	47.78439026	112.56986
	Түмэнцогт	3	47.78606895	112.5680741
	Түмэнцогт	4	47.78534077	112.5654306
	Түмэнцогт	5	47.78509613	112.5623034
	Түмэнцогт	1	47.78762902	112.5686455
	Түмэнцогт	2	47.78861739	112.5727481
	Түмэнцогт	3	47.79158133	112.5727115
	Түмэнцогт	4	47.79208378	112.5713646
	Түмэнцогт	5	47.79096568	112.5696177
	Түмэнцогт	1	47.79015797	112.5880281
	Түмэнцогт	2	47.79292501	112.5902603
	Түмэнцогт	3	47.79417375	112.5871236
	Түмэнцогт	4	47.79129572	112.5845911
	Түмэнцогт	1	47.79077447	112.5911565
	Түмэнцогт	2	47.79029855	112.5963275
	Түмэнцогт	3	47.7923903	112.5977123
	Түмэнцогт	4	47.79308697	112.5926975
	Түмэнцогт	1	47.79523807	112.5938456
	Түмэнцогт	2	47.79374369	112.5932499
	Түмэнцогт	3	47.79359915	112.5964474
Сүхбаатар				
	Түмэнцогт	1	47.78580231	112.5608111
	Түмэнцогт	2	47.78849038	112.5586868
	Түмэнцогт	3	47.78835408	112.5547366
	Түмэнцогт	4	47.7863419	112.5543121
	Түмэнцогт	1	47.78329786	112.5611791
	Түмэнцогт	2	47.78439026	112.56986
	Түмэнцогт	3	47.78606895	112.5680741
	Түмэнцогт	4	47.78534077	112.5654306
	Түмэнцогт	5	47.78509613	112.5623034
	Түмэнцогт	1	47.78762902	112.5686455
	Түмэнцогт	2	47.78861739	112.5727481
	Түмэнцогт	3	47.79158133	112.5727115
	Түмэнцогт	4	47.79208378	112.5713646
	Түмэнцогт	5	47.79096568	112.5696177
	Түмэнцогт	1	47.79015797	112.5880281
	Түмэнцогт	2	47.79292501	112.5902603
	Түмэнцогт	3	47.79417375	112.5871236
	Түмэнцогт	4	47.79129572	112.5845911
	Түмэнцогт	1	47.79077447	112.5911565
	Түмэнцогт	2	47.79029855	112.5963275
	Түмэнцогт	3	47.7923903	112.5977123
	Түмэнцогт	4	47.79308697	112.5926975
	Түмэнцогт	1	47.79523807	112.5938456
	Түмэнцогт	2	47.79374369	112.5932499
	Түмэнцогт	3	47.79359915	112.5964474

Түмэнцолг		4	47.79528452	112.5969522	880.5
Түмэнцолг		5	47.79780198	112.595102	880.9
Түмэнцолг		6	47.79732329	112.5924777	879.2
Түмэнцолг		1	47.80262659	112.6014704	879.7
Түмэнцолг		2	47.80491626	112.6009615	880.7
Түмэнцолг		3	47.80455539	112.5949084	879.9
Түмэнцолг		4	47.80289367	112.5953206	879.9
Түмэнцолг		1	47.80829942	112.6013477	879
Түмэнцолг		2	47.80447221	112.6023584	878.5
Түмэнцолг		3	47.8036406	112.6057862	878.6
Түмэнцолг		4	47.80714139	112.6049867	878
Түмэнцолг		1	47.80820484	112.6149253	878
Түмэнцолг		2	47.80697761	112.6112727	879
Түмэнцолг		3	47.80379229	112.6163163	877.5
Түмэнцолг		4	47.80570892	112.6190259	877.8
Түмэнцолг		5	47.80658704	112.6162516	878
Наран		1	45.25637676	113.7054919	1194.5
Наран		2	45.25573959	113.7044745	1194.6
Наран		3	45.25499191	113.7029914	1195.1
Наран		4	45.25458485	113.7037224	1196.8
Наран		5	45.25484976	113.706218	1198
Наран		6	45.25562752	113.7076985	1197.7
Наран		7	45.25664304	113.7080109	1194.7
Наран		8	45.25739468	113.7077329	1194.3
Наран		9	45.2587609	113.7067023	1193.6
Наран		10	45.25943604	113.705462	1195.4
Наран		11	45.25953536	113.7037426	1194
Наран		12	45.25913078	113.7040797	1192.8
Наран		13	45.2590074	113.7046928	1192.7
Наран		14	45.2588177	113.7053993	1193.8

Наран	15	45.25835945	113.7057657	1193.9
Наран	16	45.25763002	113.7061989	1193.1
Дарьганга	1	45.27789835	113.72731	1183.5
Дарьганга	2	45.27832053	113.7267303	1186.8
Дарьганга	3	45.2792918	113.725073	1181.6
Дарьганга	4	45.27880573	113.7240615	1178.4
Дарьганга	5	45.27845245	113.7239856	1178.1
Дарьганга	6	45.2780975	113.7241036	1178.4
Дарьганга	7	45.27774138	113.7244333	1179
Дарьганга	8	45.27747336	113.7251047	1179.2
Дарьганга	9	45.27693176	113.7256199	1180.8
Дарьганга	10	45.27689419	113.7258306	1180.7
Дарьганга	11	45.27692316	113.7261079	1181
Дарьганга	12	45.27699036	113.7264195	1181.3
Дарьганга	13	45.27718311	113.7267493	1181.6
Дарьганга	14	45.27751637	113.7270023	1181.1

1. Түмэнцогт сум



Талбайн дугаар	Эргэлтийн цэг	Бүрэлдэг	Уртраг
4	1	47.79015797	112.58802381
4	2	47.79282501	112.59026003
4	3	47.79417375	112.58712236
4	4	47.79123572	112.59459111

Татмын ойжуулалтын талбай нь Түмэнцогт сумын төвийг шулуун талсан хэсэгээр 25 м-г 1-р баг буюу Лүндийн багийн нутагт Хэрлэн голын таланд байрлана.

Талбайн дугаар	Эргэлтийн цэг	Бүрэлдэг	Уртраг
5	1	47.79077447	112.59115665
5	2	47.79029835	112.59632375
5	3	47.79233903	112.5977123
5	4	47.79308697	112.5926975

Тариас модны төрөл - Бургас
Хөрс - Шийт давхаргалм зузаан 18 см,
дунд шавранцар
Ус - Хэрлэн гол

Талбайн дугаар	Эргэлтийн цэг	Бүрэлдэг	Уртраг
6	1	47.79523807	112.5938466
6	2	47.79374369	112.5932499
6	3	47.79359935	112.5964474
6	4	47.79528452	112.5969522
6	5	47.79780198	112.595102
6	6	47.79333329	112.5924777

Ач холбогдол - Тухайн байршилд бургасан ой Уусх, татмын ойн талбай нэмэгдэх, хөрсний эвдрэл, үерийн эрсдэлтэй хамталах


Түмэнцогт суманд 2024 онд хийгдэх Татмын ойжуулалтын ажлын байрзүйн зураг (талбай 4-6)



Таних тэмдэг

- Түмэнцогт сумын хил
- Баягуулын хил
- Түмэнцогт-Ойжуулалт-2024-4 - Талбай 10 га
- Түмэнцогт-Ойжуулалт-2024-5 - Талбай 10 га
- Түмэнцогт-Ойжуулалт-2024-6 - Талбай 10 га
- Эргэлтийн цэгүүд

Түмэнцогт суманд 2024 онд хийгдэх Татмын ойжуулалтын ажлын байрзүйн зураг




Талбайн дугаар	Эргэлтийн цэг	Өргөрөг	Уртраг
1	47.78590231	112.5608111	
1	47.7849038	112.5586868	
1	47.78335408	112.5547366	
1	47.7833419	112.5543121	

Татмын ойжуулалтын талбай нь Түмэнцогт сумын төвдөс шулуун татсан хэмжээгээр 28 м²-т 1-р баг буюу Лхунбэр балгын нутагт Хэрлэн голын таланд байрлана.

Талбайн дугаар	Эргэлтийн цэг	Өргөрөг	Уртраг
2	47.7825786	112.5611791	
2	47.78439026	112.56896	
2	47.78606895	112.5680741	
2	47.7834077	112.5654306	
2	47.78609613	112.5623034	

Тэрхж морчи төрөл - Бургас
Хөрс - Шингт давхрагын зузаан 18 см,
дунд шавранцар
Ус - Хэрлэн гол

Ач хойбогдол - Тухайн байршилд бургасан ой үүсэх, татмын ойн талбай нэмэгдэх, хөрсний эдрэл, үерийн эрсдэлээс хамгаалах




2406400E 2407200E 2408000E

5818400N

5817600N

**Түмэнцогт суманд 2024 онд хийгдэх
Татмын ойжуулалтын ажлын
байрзүйн зураг (талбай 7-9)**



Татмын ойжуулалтын талбай нь Түмэнцогт сумын төвд оршдог тул тус тус хэмжээгээр 32 км-г 1-р баг буюу Лхунбо багийн нутагт Хэрлэн голын татаанд байрлана.


Талбайн дугаар	Эргэлтийн цэг	Өргөрөг	Уртраг
7	1	47.80262659	112.6014704
7	2	47.80491626	112.6009615
7	3	47.80455339	112.5949084
7	4	47.80289367	112.5953206

Тариак модны төрөл - Бургас
Хөрс - Шингт дөвсрэгэн зузаан 26 см,
дунд шөрвөрснээр
Ус - Хэрлэн гол


Талбайн дугаар	Эргэлтийн цэг	Өргөрөг	Уртраг
8	1	47.80823942	112.6013477
8	2	47.80447221	112.6023584
8	3	47.8036406	112.6037862
8	4	47.80714139	112.6049867

Ач холбогдол - Турайн байршилд бургасан ой үүсэх, татмын ой талбайн нэмэгдэх, хөрсний эвдрэл, Усгийн эрсдэлээс хамгаалах


Талбайн дугаар	Эргэлтийн цэг	Өргөрөг	Уртраг
9	1	47.80820484	112.6149253
9	2	47.80697761	112.6112727
9	3	47.80379229	112.6163163
9	4	47.80570892	112.6190259
9	5	47.80658704	112.6162516



2. Дарьганга сум



Дарьганга суманд 2024 онд хийгдэх Татмын ойжуулалтын ажлын байрзүйн зураг




Эргэлтийн цэг	Өргөрөг	Уртраг
1	45.27789835	113.727231
2	45.27832053	113.7267303
3	45.2792918	113.725073
4	45.27880573	113.7240615
5	45.27845245	113.7239856
6	45.2780975	113.7241036
7	45.27774138	113.7244333
8	45.27747336	113.7251047
9	45.27693176	113.7256199
10	45.27689419	113.7258306
11	45.27692316	113.7261079
12	45.27699036	113.7264195
13	45.27718311	113.7267493
14	45.27751637	113.7270023

2024 онд, Дарьганга суманд хийгдэх Татмын ойжуулалтын ажлын байршил нь сумын төвөөс баруун тийш 10 км, 4-р баг, Овоот, Баянголын зүүн эрэгт байрлана. Нийт 4 га талбайг 820 м урт хашаагаар хамгаална.

Төрих модны төрөл - Хайлаас
Хөрс - Шинг давхарга 6-8 см, дунд шаарцар, элсэрхэг
Ус - Баянгол
Ач холбогдолт - Хөрсний элгүүлэл, элсний нүүдлээс хамгаалах

3. Наран сум



Наран суманд 2024 онд хийгдэх Татмын ойжуулалтын ажлын байрзүйн зураг



2024 онд Наран суманд хийгдэх Татмын ойжуулалтын ажлын байршил нй сумын төвөөс зүүн хойд зүгт шулуун татсан хэргэлдээр 16 км, 1-р баг буюу Гүн худар болгийн Өлзийт булаг-ийн таланд байрлана. Нийт 9 га талбайг 1800 м урт хашаагаар хамгаална.

Тариx модны төрөл - Бургас, Хайлаас
Хөрс - Шинг дэвхэргийн сузсан 2.1см, дунд шавранцар, элсэрхэг
Ус - Өлзийт булаг

Ач холбогдол - Өлзийт булагийн үндэргэд зөргөөр нөлөөлөх, ойн талбай тэлж ургах, хөрсний элэлдэл элсний нүүдлээс хамгаалах

Эргэлтийн цэгүүд	Өргөрөг	Урлаг
1	45.25837676	113.7054919
2	45.25873899	113.7044745
3	45.25489181	113.7028914
4	45.25456485	113.7037224
5	45.254694976	113.7092718
6	45.255682752	113.7076885
7	45.25664394	113.7080109
8	45.2587669	113.7097023
9	45.25943804	113.7054802
10	45.25853538	113.7037426
11	45.25913078	113.7040787
12	45.25900074	113.7046828
13		
14	45.2588177	113.7053883
15	45.259359645	113.7057857
16	45.25783002	113.7081889